



The Asia Foundation

SURVEY

**БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ
АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГАА**

2017
UIH.MN
СУДАЛГААНЫ САН



Энэхүү судалгааг Канадын Гадаад хэргийн яамны дэмжлэгтэйгээр Азийн сан, Сант Марал сантай хамтран явуулсан бөгөөд судалгааны үр дүн нь Канадын Засгийн газар болон Азийн сангийн үзэл бодлыг илэрхийлээгүй болохыг анхаарна уу.

БИЗНЕС ЭРХЛЭЛТИЙН ОРЧИН ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГАА

2017

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

2017

АГУУЛГА

Хүснэгт, дүрсийн жагсаалт	5
Оршил	8
Судалгааны гол үр дүн	9
Судалгааны арга зүй	11
I. Түүврийн тодорхойлолт	13
II. Бизнесийн орчин	21
III. Бизнесийн орчны хүндрэл бэрхшээлүүд	29
IV. Алдагдал буюу үр ашиггүй зарцуулалт	33
V. Төрийн албан дахь авлига	37
VI. Хувийн хэвшил дэх авлига	47
VII. Авлигатай тэмцэх үйл ажиллагаа	57

ХҮСНЭГТ, ДҮРСИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1	Бүхшатны боловсролын байгууллагын төгсөгчид, хичээлийн жилийн эхэнд	19
Зураг 1.1	Газар зүйн хуваарилалт	15
Зураг 1.2	Үйл ажиллагааны чиглэл	15
Зураг 1.3	Хөрөнгийн хэмжээ	16
Зураг 1.4	Байгуулагдсан он	16
Зураг 1.5	Удирдлагын хүйсийн бүтэц	17
Зураг 1.6	Хөрөнгийн хэмжээгээр харуулсан хүйсийн харьцаа	17
Зураг 1.7	Хүйсийн харьцаа, үйл ажиллагааны чиглэлээр	18
Зураг 1.8	Удирдлагын насны бүлгүүд	18
Зураг 2.1	Та бизнес эрхлэлтийн ерөнхий орчинд сэтгэл хангалуун байдаг уу?.....	22
Зураг 2.2	Бизнесийн орчны үнэлгээний дундаж (утга)	23
Зураг 2.3	Бизнесийн орчны сэтгэл ханамжийн байдал, хүйсээр (2017)	23
Зураг 2.4	Бизнес эрхлэлтийн ерөнхий орчинд сэтгэл хангалуун байдал, бизнесийн хэмжээгээр (2017)	24
Зураг 2.5	Бизнесийн орчны дундаж үнэлгээ, бизнесийн хэмжээгээр (2012-2017) ...	24
Зураг 2.6	Бизнесийн орчны дундаж үнэлгээ компанийн үйл ажиллагааны чиглэлээр (2012-2017)	25
Зураг 2.7	Сүүлийн 6 сарын хугацаанд компанийн үйл ажиллагааны хөрөнгө оруулалтын нөхцөл байдал	26
Зураг 2.8	Ирэх 6 сарын хугацаанд таны компанийн үйл ажиллагааны хөрөнгө оруулалтын нөхцөл байдал.....	26
Зураг 2.9	Сүүлийн 6 сарын хугацаанд компанийн үйл ажиллагааны хөрөнгө оруулалт хөрөнгө оруулалтын нөхцөл байдал (хүйсээр)	27
Зураг 2.10	Ирэх 6 сарын хугацаанд таны компанийн үйл ажиллагааны хөрөнгө оруулалтын нөхцөл байдал (хүйсээр)	27
Зураг 2.11	Өнгөрсөн жилийн хугацаанд засгийн газар эдийн засгийн бодлогоо хэр үр дүнтэй хэрэгжүүлсэн бэ?	28
Зураг 2.12	Өнгөрсөн жилийн хугацаанд засгийн газар эдийн засгийн бодлогоо тогтвортой хэрэгжүүлж чадсан уу?	28
Зураг 3.1	Бизнесийн үндсэн бэрхшээлүүд (олон сонголттой)	30
Зураг 3.2	Бизнест тулгарч буй хамгийн гол 3 бэрхшээлийн 2012-2017 оны чиг хандлага	31
Зураг 3.3	Бэрхшээл учруулж буй 4 тэргүүлэх байгууллагын чиг хандлага	31
Зураг 3.4	Бизнест бэрхшээл учруулж буй байгууллагууд (2017)	32

Зураг 3.5	Бэрхшээл учруулж буй байгууллагууд (хүйсээр)	32
Зураг 4.1	Танай компани зөвшөөрөл, лиценз авах, сунгах, албан ёсны хариу хүлээх гэх мэт үйлдвэрлэлийн бус асуудлуудыг шийдвэрлэхэд ажлын цагийн хэдэн хувийг үр ашиггүй зарцуулдаг вэ?	34
Зураг 4.2	Танай компани зөвшөөрөл, лиценз авах, сунгах, албан ёсны хариу хүлээх гэх мэт үйлдвэрлэлийн бус асуудлуудыг шийдвэрлэхэд хөрөнгө мөнгөний хэдэн хувийг үр ашиггүй зарцуулдаг вэ?	35
Зураг 4.3	Танай компани зөвшөөрөл, лиценз авах, сунгах, албан ёсны хариу хүлээх гэх мэт үйлдвэрлэлийн бус асуудлуудыг шийдвэрлэхэд ажлын цагийн хэдэн хувийг үр ашиггүй зарцуулдаг вэ? (хүйсээр)	35
Зураг 4.4:	Танай компани зөвшөөрөл, лиценз авах, сунгах, албан ёсны хариу хүлээх гэх мэт үйлдвэрлэлийн бус асуудлуудыг шийдвэрлэхэд хөрөнгө мөнгөнийхөө хэдэн хувийг үр ашиггүй зарцуулдаг вэ? (хүйсээр)	36
Зураг 5.1	Таны бодлоор төрийн байгууллагуудад авлига хэр их байна вэ?	38
Зураг 5.2	Таны бодлоор төрийн байгууллагуудад авлига хэр их байна вэ?	39
Зураг 5.3	Танай салбар дахь төрийн байгууллага болон компанийн харилцаанд авлигын чанартай зүйл байгааг та хамгийн сүүлд хэзээ ажигласан бэ? (зөвхөн бодит)	39
Зураг 5.4	Төрийн байгууллагын тендер болон гэрээ байгуулах ажиллагаанд авлига хэр их байна вэ? (зөвхөн бодит хариулт)	40
Зураг 5.5	Төрийн байгууллага дахь авлигын давтамжийн дундаж	40
Зураг 5.6	Төрийн байгууллага, агентлагуудаас аль нь хамгийн их авлигад өртсөн бэ? (олон сонголттой хариулт)	41
Зураг 5.7	Төрийн байгууллага дахь авлига танай бизнест шууд нөлөөлж байна уу? (зөвхөн бодит)	43
Зураг 5.8	Танай компани засгийн газрын тендерт оролцдог уу?	43
Зураг 5.9	Их авлига буюу дээд түвшний авлига танай бизнест хэр их нөлөөлж байна вэ?	44
Зураг 5.10	Төрийн байгууллага дахь авлига хувь хүмүүс хоорондын харилцааны хүрээнд байна уу, эсвэл зохион байгуулалттай бүлэглэлийн хэмжээнд очсон байна уу?	45
Зураг 5.11	Хэрэв у.хүрэлсүх ерөнхий сайд болвол төрийн тендер болон худалдан авах ажиллагаа өмнөх засгийн газартай харьцуулахад хэр их өөрчлөгдөх вэ?	45
Зураг 5.12	Таны бодлоор улс төр, гэр бүл, ах дүү, танилын харилцаа тендерийн үр дүнд нөлөөлдөг үү?	45
Зураг 5.13	Өнгөрсөн гурван жилд Монголын бизнесийн орчинд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдсөн бэ?	45

Зураг 6.1	Тувийн хэвшилд авлига хэр их байна вэ? (зөвхөн хүчинтэй хариулт).....	48
Зураг 6.2	Хувийн хэвшилд авлига хэр их байна вэ? (хүйсээр)	49
Зураг 6.3	Хувийн хэвшил дэх тендер болон гэрээ байгуулах ажиллагаанд авлига хэр их тохиолддог вэ? (зөвхөн хүчинтэй хариулт)	50
Зураг 6.4	Танай бизнесийн салбарт үйл ажиллагаа явуулахад авлига хэр их тохиолддог вэ? (зөвхөн хүчинтэй хариулт)	51
Зураг 6.5	Танай салбарт бизнесийн үйл ажиллагаа явуулахад авлига хэр их тохиолддог вэ?	52
Зураг 6.6	Авлигад хамгийн өртөмтгий салбар (олон хариулт)	54
Зураг 6.7	Танай салбарт хэр олон компаниуд татвараа номоор нь /хууль ёсны дагуу/ төлдөг вэ? (зөвхөн бодит)	56
Зураг 7.1	Та засгийн газраас явуулж байгаа авлигын эсрэг үйл ажиллагааны талаар хэр сайн мэдэх вэ?	58
Зураг 7.2	Одоогийн үйлчилж байгаа авлигын эсрэг хууль тогтоомж бизнесийн орчныг ил тод, авлигагүй болгоход хэр үр дүнтэй байна вэ?	59
Зураг 7.3	6 Сарын өмнөхтэй харьцуулбал засгийн газраас хэрэгжүүлж буй авлигын эсрэг арга хэмжээний үр дүнд нөхцөл байдал өөрчлөгдсөн үү? ...	60
Зураг 7.4	Ерөнхийд нь авч үзвэл засгийн газраас хэрэгжүүлж буй авлигын эсрэг арга хэмжээнүүд монголыг авлигагүй болгоход хэр үр дүнтэй байна вэ? ...	61
Зураг 7.5	Засгийн газар авлигач албан тушаалтнуудад хариуцлага тооцож чадаж байна уу?.....	62
Зураг 7.6	Зөвхөн хээл хахууль авсан талд хариуцлага тооцохоор хуульд өөрчлөлт оруулбал үр дүнтэй гэж зарим хүмүүс үздэг. Зарим нь өгсөн, авсан аль алинд хариуцлага тооцох ёстой гэж үздэг. Таны бодол?	62
Зураг 7.7	Хэрэв төрийн байгууллагуудад авлига багасвал танай компанийн нийт орлого нэмэгдэх үү, буурах уу, эсвэл хэвээр үлдэх үү.....	63
Зураг 7.8	Танай компани авлигатай тэмцэх ямар нэгэн алхам хийсэн үү?	64
Зураг 7.9	Та авлигын талаар мэдээлэл өгч байсан уу?.....	64
Зураг 7.10	Хэрвээ өгсөн бол ямар нэг үр дүнд хүрч байсан уу?	65
Зураг 7.11	Танай байгууллагад авлигын эсрэг дотоод дүрэм журам бий юу?	66
Зураг 7.12	Бизнесийн орчин дахь авлигаыг арилгахын тулд танай байгууллага ямар аргыг сонгох вэ?	66
Зураг 7.13.	Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг та хэрхэн үнэлж байна вэ?	67

ОРШИЛ

Азийн сан Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал судалгааг Сант Марал сантай хамтран найм дахь удаагаа нийслэл Улаанбаатар хотод байрладаг аж ахуйн нэгжүүдийн дунд 2017 оны 10 сард явууллаа.

Судалгаа нь Канадын Гадаад хэргийн яамны санхүүжилтээр Азийн сан хэрэгжүүлж буй “Ардчилсан оролцоотойгоор төрийн албанд сайн засаглал, ил тод байдлыг бэхжүүлэх нь” (STEPS) төслийн салшгүй нэг хэсэг юм. Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал судалгаа нь бизнес эрхлэгчдийн ойлголт төсөөлөлд тулгуурлан авлига бизнесийн орчинд хэрхэн нөлөөлж буйг харуулахыг зорьдог.

Энэхүү судалгаа нь хувийн хэвшил болон төр, тэдгээрийн хоорондох харилцааны мэдээлэлд тулгуурлан бизнесийн орчны шинэчлэл хийх боломжуудын талаар мэдээлэл цуглуулдаг. Судалгааг урт хугацаанд, тогтмол давтамжтай хийснээр ойлголт, хандлагад гарч буй өөрчлөлтийг харьцуулах, үнэлэх боломжийг олгодог юм. Судалгааны зорилго нь бизнес эрхлэгчид, бодлого тодорхойлогчид, ялангуяа төрийн үйлчилгээний байгууллагуудын засаглал, менежментыг сайжруулах, хандлагыг өөрчлөх мөн авлигаас урьдчилан сэргийлэхэд оршино. Азийн сан Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа мөн явуулдаг бөгөөд энэхүү хоёр судалгаа хамтдаа Монгол Улс дахь авлигын дүр зургийг харуулахыг зорьдог юм. Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал судалгаа нь STEPS төслийн хугацаанд жил бүр хийгдэх болно.

СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН

- Эдийн засгийн үзүүлэлтүүдийг 2016 онтой харьцуулахад дараах байдлаар сайжирсан байна:
 - o Бизнесийн орчны эерэг үнэлгээ 2016 оны 12.1-ээс 2017 онд 18.5 хувь болж өссөн. Бизнесийн орчны сэтгэл ханамжийн байдлыг хүйсийн бүлгээр харьцуулан харвал эмэгтэйчүүдийн үнэлгээ өөдрөг бус байна
 - o Хөрөнгө оруулалтын нөхцөл байдлыг 2016 оны 10 хувьтай харьцуулахад 2017 онд 17.3 хувь болж нэмэгдсэн
 - o Түүнчлэн 2016 онд судалгаанд оролцогчдын 26.4 хувь нь хөрөнгө оруулалт нэмэгдэнэ гэх хүлээлттэй байсан бол 2017 онд энэ үзүүлэлт 44.8 хувь болж өссөн
- Судалгаанд оролцогчдын 37 хувь нь бизнесийн орчин дахь авлига 3 жилийн өмнөхтэй харьцуулахад өссөн гэж үзсэн. Ердөө 11.8 хувь нь нөхцөл байдал сайжирсан гэсэн бол 51.3 хувь нь өөрчлөгдөөгүй гэж дүгнэсэн
- Судалгаанд оролцогчдын 21.6 хувь нь Засгийн газрын эдийн засгийн бодлогыг үр дүнтэй гэж үзсэн бол 62.4 хувь нь өнгөрсөн 1 жилийн хугацаанд эдийн засгийн бодлогоо тогтвортой хэрэгжүүлж чадаагүй гэж үзэж байна;
- “Тусгай зөвшөөрөл, лиценз олголт ба сунгалт”, “албан бус хураамж”, “түр зуурын хориг, саад”-ийг бизнест тулгардаг бэрхшээл гэж үзэх тоон үзүүлэлт 2012-2017 онуудад мэдэгдэхүйц буурчээ
- “Татварын өндөр хувь хэмжээ” нь бизнест тулгарч буй хамгийн том бэрхшээл хэвээр байгаа ч татварын албанаас бизнест учруулж буй бэрхшээл багассан гэж үнэлсэн байна. Энэ нь 2016 онд 35.5 хувь байсан бол 2017 онд 22.7 хувь болж буурсан
- Судалгаанд оролцогчдын тал хувь нь төрийн байгууллагуудад авлига “маш их” байна гэж хариулснаар төрийн салбар дахь авлига огцом өссөн харагдаж байна
- Өмнөх жилүүдтэй харьцуулахад төрийн тендерийн нөхцөл байдал 2016, 2017 онд сайжирсан шинж тэмдэг илэрч байна
- “Авлигад өртсөн” байгууллагын хувьд Ашигт малтмал, газрын тосны газар 2016 оны 3.3%-иас 2017 онд 13% болж хамгийн ихээр өссөн
- Ерөнхий сайд УХүрэлсүхийн Засгийн газарт итгэх итгэлийн түвшин эерэг байна. Судалгаанд оролцогчдын 4.8 хувь нь тендер шалгаруулалтын нөхцөл байдал муудна гэж үзсэн бол 35.5 хувь нь сайжирна гэсэн хүлээлттэй байна. Харин 19.1 хувь нь нөхцөл байдал хэвээр үлдэнэ гэж үзсэн, 40.6 хувь нь санал бодлоо илэрхийлээгүй

- Хувийн хэвшил дэх авлига харьцангуй бага байгааг судалгааны дүн харуулж байна. 2012-2015 оны үзүүлэлтээс харахад хувийн хэвшил дэх авлигын түвшин буурчээ
- “Уул уурхай” болон “төрийн үйлчилгээ” нь авлигад хамгийн өртөмтгий салбаруудын тоонд орсон хэвээр байна
- Судалгаанд оролцогчдын 72.1 хувь одоогийн хууль эрх зүйн орчин бизнесийн орчныг ил тод, авлигагүй болгох тал дээр “үр дүн багатай” эсвэл “огт үр дүнгүй” гэж үзсэн;
- Судалгаанд оролцогчдын 71.5 хувь нь авлигатай тэмцэх Засгийн газрын үйл ажиллагааг “үр дүн багатай” эсвэл “огт үр дүнгүй” гэж үзэж байна
- Судалгаанд оролцогчдын 47.3 хувь авлига буурсан тохиолдолд бизнесийн нь цэвэр орлого нэмэгдэнэ гэсэн итгэлтэй байхад, үлдсэн хэсэг нь авлига буурахад бизнест аливаа эерэг үр дүн гарна гэж үзэхгүй эсвэл үнэлж чадахгүй байна
- Бизнес эрхлэгчид авлигатай тэмцэж бизнесийн орчныг сайжруулах санал санаачлага бага, идэвхгүй байр суурьтай байна

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

1. Судалгааг Ардчилсан оролцоотойгоор төрийн албанд сайн засаглал, ил тод байдлыг бэхжүүлэх нь” (STEPS) төслийн хүрээнд Сант Марал сан гүйцэтгэсэн болно. Судалгааны мэдээллийг 2017 оны 9 сарын 27-ноос 10 сарын 12-ны хооронд цуглуулав.
2. Судалгаанд оролцогчид нь Улаанбаатар хотын бизнес эрхлэгчид бөгөөд өмнөх судалгааны үеэр цуглуулсан мэдээлэлд үндэслэн ойролцоогоор 1300 компанийн жагсаалтыг гаргасан. Үүнээс судалгаанд оролцох 330 компанийг санамсаргүйгээр сонгож авсан. Түүвэрт том бизнес, жижиг болон дунд хэмжээний компанийн төлөөлөл бүгд ойролцоо тоогоор хамрагдсан. Судалгаанд зөвхөн 100 хувь Монголын хөрөнгө оруулалттай компаниуд хамрагдсан.
3. Түүвэрлэлтийн явцад гарсан зөрүүг дараах байдлаар тооцоолсон байна: 90/10 хувьд ± 3.2 хувь, 50/50 хувьд ± 5.4 хувь, 60/40 хувьд ± 5.3 хувь ба харьцуулж буй бүлгүүдийг статистикийн ач холбогдлын түвшин 95 хувь байна.
4. Мэдээлэл цуглуулалтыг судалгаанд оролцогчоор өөрөөр нь хариултыг бичүүлэх эсвэл ганцаарчилсан ярилцлагын аргыг ашигласан.
5. Ярилцлага болон асуулгыг зөвхөн компанийн гүйцэтгэх захирал, эсхүл удирдлагын түвшний ажилтнаас авсан.

ТҮҮВРИЙН ТОДОРХОЙЛОЛТ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

I. ТҮҮВРИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2017 онд судалгааны түүвэрлэлтийн бүтцийг өмнөх хэмжүүрүүдтэй адил хэвээр хадгалсан. Газар зүйн хуваарилалтыг өмнөх судалгаатай ижил хувь хэмжээнд үлдээсэн. 2012-оос 2017 он хүртэл хугацаанд судалгаанд оролцогч бизнесүүдийн бүтцэд өөрчлөлтүүд ажиглагдлаа. 2012 оноос хойш түүвэрт худалдааны салбарын хувь хэмжээ буурч, үйлчилгээний салбарын хувь хэмжээ нэмэгдэж байна (Зураг 1.2). Гэвч энэ нь бизнес эрхлэгчдийн дөрөвний нэг орчим нь нэгээс илүү чиглэлд үйл ажиллагаа явуулж байгаатай холбоотой. Аж ахуйн нэгжүүд үйлчилгээ болон худалдааны салбарт аль алинд нь идэвхтэй үйл ажиллагаа явуулах нь нийтлэг болсон, мөн зарим үйлдвэрлэгчид өөрсдийн бүтээгдэхүүнээ борлуулж эсвэл нэмэлт үйлчилгээ үзүүлж байна.

2017 онд өмнөх жилтэй харьцуулахад түүвэрт дунд хэмжээний бизнесийн хувь хэмжээ нэмэгдсэн байхад жижиг бизнесийн хувь хэмжээ буурсан (Зураг 1.3).

2007 оноос өмнө буюу шилжилтийн үед байгуулагдсан компаниудын тоо тогтмол буурч байна¹ (Зураг 1.4). 2000 оноос өмнө байгуулагдсан компаниудын хувийн жин тогтвортой байгаа хэдий ч 2000-2006 онд байгуулагдсан компаниуд аажмаар цөөрч байна. Тэдгээрийг шилжилтийн үеийн дараа байгуулагдсан шинэ аж ахуйн нэгжүүд орлож байна.


Сант Марал сан 2017 онд анх удаа удирдлагын талаар тойм зураг гаргахын тулд хүн ам зүйн үндсэн мэдээллийг судалгаанд оролцсон дээд түвшний удирдлагаас цуглууллаа. Судалгаанд оролцсон удирдах албан тушаалтнуудын нас голчлон залуу байна (Зураг 1.7). Насны хамгийн том бүлэг 30-39 насныхан 37,6 хувийг, 50 ба түүнээс дээш насныхан 15,8 хувийг эзэлж байна.

Хүйсийн бүтцийг авч үзвэл удирдах албанд эмэгтэйчүүдийн эзлэх хувь улсын хэмжээний хүйсийн хуваарилалтаас илүү өндөр байна (Зураг 1.5). Энэхүү зөрүү нь шилжилтийн болон шилжилтийн дараах үеийн Монголын хөдөлмөрийн зах зээл эмэгтэйчүүдийн талд тааламжтай ч хүйсийн харьцаа тэнцвэргүй байсантай холбоотой. Дээд боловсрол эзэмшсэн эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдээс илүү өндөр байна (Хүснэгт 1.1). 2007-2016 оны хичээлийн жилийн эхэн дэх бүх шатны боловсролын байгууллагын төгсөгчдийн тоог харуулав (Үндэсний статистикийн эмхтгэл 2016). Энэ мэдээллийн дагуу өнгөрсөн 10 жилийн хугацаанд их, дээд сургууль, коллеж төгсөгчдийн 60 гаруй хувь нь эмэгтэйчүүд байжээ.


Нийт удирдлагын түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх хувь харьцангуй өндөр байгаа хэдий ч компанийн хэмжээ томрохын хэрээр тэдний тоо буурч байна (Зураг 1.6). Эмэгтэйчүүд илүү жижиг бизнесийг удирдан явуулдаг бөгөөд тэдгээрийн үйл ажиллагаа ихэвчлэн үйлчилгээ эсвэл худалдааны салбарт байна.

¹ 2007 он нь Монгол улсын шилжилтийн үе дууссан цаг гэж тооцогддог.


Зураг 1.1: Газар зүйн хуваарилалт




Зураг 1.2: Үйл ажиллагааны чиглэл





Зураг 1.3: Хөрөнгийн хэмжээ




Зураг 1.4: Байгуулагдсан он




Зураг 1.5: Удирдлагын хүйсийн бүтэц**Зураг 1.6:** Хөрөнгийн хэмжээгээр харуулсан хүйсийн харьцаа

Зураг 1.7: Хүйсийн харьцаа, үйл ажиллагааны чиглэлээр



Зураг 1.8: Удирдлагын насны бүлгүүд



Хүснэгт 1.1: Бүх шатны боловсролын байгууллагын төгсөгчид, хичээлийн жилийн эхэнд

Боловсролын байгууллагуудын ангилал	2006/2007	2007/2008	2008/2009	2009/2010	2010/2011	2011/2012	2012/2013	2013/2014	2014/2015	2015/2016	Бүгд 2007- 2016
Бүгд	133	134.5	134	139.5	134	168	151	137	128	112	1,370
Үүнээс: эмэгтэй %	55%	55%	55%	55%	55%	54%	54%	53%	53%	53%	54%
Ерөнхий боловсролын сургуулиуд	100	96	90	90	87	107	90	85	74	56	875
Үүнээс: эмэгтэй %	53%	53%	53%	52%	52%	52%	52%	51%	51%	52%	52%
Техник мэргэжлийн сургууль	7	9	11	15	11	23	23	18	19	20	157
Үүнээс: эмэгтэй %	49%	46%	47%	48%	47%	49%	44%	43%	43%	41%	45%
Их сургууль, дээд сургууль, коллеж	26	30	33	34	36	38	37	34	35	36	339
Үүнээс: эмэгтэй %	65%	66%	64%	65%	64%	64%	64%	64%	62%	61%	64%

Эх сурвалж: Монгол Улсын статистикийн эмхтгэл 2016

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БИЗНЕСИЙН ОРЧИН


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

II. БИЗНЕСИЙН ОРЧИН


Судалгааны нийт хугацааны турш буюу 2012-2017 онд бизнесийн орчны үнэлгээ ихэнхдээ сөрөг байсан (Зураг 2.1). Хамгийн сайн үзүүлэлт 2012 оны 12 сард 33.2 хувийн эерэг үнэлгээ, 67.3 хувийн сөрөг үнэлгээтэй байсан. Хамгийн муу үзүүлэлт 2016 оны 9 сард 12.1 хувийн эерэг үнэлгээний эсрэг 86 хувийн сөрөг үнэлгээтэй байв. Бууралтын хандлага 2017 онд өөрчлөгдсөн. Эерэг үнэлгээ 6.4 хувиар өсч, өнгөрсөн оны 12.1 хувиас 18.5 хувь болсон.

Хэрэв 5 жилийн үнэлгээний дунджийг харвал (Зураг 2.2) -0.83 буюу 2017 оны 9 сарын үнэлгээ нь 2013 оны 9 сарын -0.80 дундажтай ойролцоо байна.

Зураг 2.1: Та бизнес эрхлэлтийн ерөнхий орчинд сэтгэл хангалуун байдаг уу?




Зураг 2.2: Бизнесийн орчны үнэлгээний дундаж (утга) (сэтгэл маш хангалуун: +2, сэтгэл бага зэрэг хангалуун: +1, сэтгэл бага зэрэг хангалуун бус: -1, сэтгэл маш хангалуун бус: -2)




Бизнесийн орчны сэтгэл ханамжийн байдлыг хүйсийн бүлгээр харьцуулан харвал эмэгтэйчүүдийн үнэлгээ өөдрөг бус байна (Зураг 2.3). Эрэгтэй менежерүүдийн 22.3 хувь нөхцөл байдлыг эерэгээр үнэлж байхад ("маш сэтгэл хангалуун" болон "бага зэрэг сэтгэл хангалуун" хоёрын нийлбэр), эмэгтэй менежерүүдийн зөвхөн 15.9 хувь нь ижил үзэж байна. Энэхүү зөрүү нь компаниудын хэмжээ болон үйл ажиллагааны чиглэлтэй хамааралгүй болох нь харагдсан.

Зураг 2.3: Бизнесийн орчны сэтгэл ханамжийн байдал, хүйсээр (2017)




2017 онд жижиг бизнесүүд дунд хэмжээний компаниудыг бодвол бизнесийн орчинг харьцангуй сайн үнэлсэн (Зураг 2.4, 2.5). 2016 онтой харьцуулахад (Зураг 2.5) эерэг үнэлгээний өсөлт жижиг бизнест бүртгэгдсэн байхад дунд болон том бизнесийн эерэг үнэлгээний өсөлт бага байв. 2012-2017 оны хооронд хийгдсэн бизнесийн орчны хамгийн тааруу үнэлгээг уул уурхай болон барилгын салбарын компаниуд өгсөн (Зураг 2.6).


Зураг 2.4: Бизнес эрхлэлтийн ерөнхий орчинд сэтгэл хангалуун байдал, бизнесийн хэмжээгээр (2017)



Зураг 2.5: Бизнесийн орчны дундаж үнэлгээ, бизнесийн хэмжээгээр (2012-2017)




Зураг 2.6: Бизнесийн орчны дундаж үнэлгээ компанийн үйл ажиллагааны чиглэлээр (2012-2017)




Бизнесийн орчны эерэг өөрчлөлтөд сүүлийн 6 сарын хугацаанд хөрөнгө оруулалтын нөхцөл байдал сайжирсан үнэлгээ орж байна (Зураг 2.7). Хөрөнгө оруулалтын нөхцөл байдал “сайжирсан” гэсэн үнэлгээ 7.3 хувиар өссөн бол “дордсон” гэсэн үнэлгээ 22.8 хувиар буурсан байна. Ирээдүйн хөрөнгө оруулалтын талаарх хандлага өөдрөг байна (Зураг 2.8). Судалгаанд оролцогчдын 44.8 хувь нөхцөл байдал сайжрах хүлээлттэй байх бөгөөд энэ нь өнгөрсөн онохоос 18.4 хувиар их байна.

Хөрөнгө оруулалтын нөхцөл байдлын үнэлгээнд хүйсийн онцгой ялгаа ажиглагдаагүй (Зураг 2.9). Гэсэн хэдий ч ирээдүйн хөрөнгө оруулалтын талаар хариулт өгөөгүй эмэгтэй оролцогчид эрэгтэй оролцогчдоос илүү олон байна. Тодруулбал, эрэгтэйчүүдийн 6.8, эмэгтэйчүүдийн 19.3 хувь нь “мэдэхгүй эсвэл хариулт өгөөгүй” байна (Зураг 2.10).


Зураг 2.7: Сүүлийн 6 сарын хугацаанд компанийн үйл ажиллагааны хөрөнгө оруулалтын нөхцөл байдал




Зураг 2.8: Ирэх 6 сарын хугацаанд таны компанийн үйл ажиллагааны хөрөнгө оруулалтын нөхцөл байдал



Зураг 2.9: Сүүлийн 6 сарын хугацаанд компанийн үйл ажиллагааны хөрөнгө оруулалт хөрөнгө оруулалтын нөхцөл байдал (хүйсээр)




Зураг 2.10: Ирэх 6 сарын хугацаанд таны компанийн үйл ажиллагааны хөрөнгө оруулалтын нөхцөл байдал (хүйсээр)




Үндэсний эдийн засаг зарим талаараа сайжирсан хэдий ч судалгаанд оролцогчдын 60.9 хувь Засгийн газар өнгөрсөн жилийн хугацаанд “үр дүн багатай” эсвэл “огт үр дүнгүй” ажилласан гэж үзсэн (Зураг 2.11). Мөн 62.4 хувь нь Засгийн газар өнгөрсөн жил эдийн засгийн тогтвортой бодлоготой байгаагүй гэж үзэж байна (Зураг 2.12).

Зураг 2.11: Өнгөрсөн жилийн хугацаанд Засгийн газар эдийн засгийн бодлогоо хэр үр дүнтэй хэрэгжүүлсэн бэ?



Зураг 2.12: Өнгөрсөн жилийн хугацаанд Засгийн газар эдийн засгийн бодлогоо тогтвортой хэрэгжүүлж чадсан уу?




БИЗНЕСИЙН ОРЧНЫ ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛҮҮД

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

III. БИЗНЕСИЙН ОРЧНЫ ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛҮҮД

Бизнесийн хүндрэл бэрхшээлийн 2017 оны үзүүлэлтийг өнгөрсөн 5 жилийн дундажтай харьцуулж үзвэл ихэнх үзүүлэлтүүд буурсан эерэг хандлага харагдаж байна (Зураг 3.1). "Тусгай зөвшөөрөл, лиценз шинээр авах, сунгуулах", "албан бус төлбөр", "түр зуурын хориг, хязгаарлалт" гэсэн 3 шалгуур үзүүлэлтийн бууралт нь авлигын түвшин буурч байгаагийн нэг илрэл байж болох юм. Тодруулбал "түр зуурын хориг, хязгаарлалт" 13.4 хувиас 9.7 хувь, "албан бус төлбөр" 10.7 хувиас 8.2 хувь хүртэл, "тусгай зөвшөөрөл, лиценз шинээр авах, сунгуулах" үзүүлэлт мөн 0.7 хувиар буурчээ.


Зураг 3.1: Бизнесийн үндсэн бэрхшээлүүд (олон сонголттой)



Өмнөх онтой харьцуулбал 2015-2016 онд ажиглагдсан "өндөр татвар"-ын сөрөг хандлага буурсан хэдий ч (Зураг 3.2) судалгаанд оролцогчдын 51.2 хувь үүнийг бэрхшээл гэж үзсэн


хэвээр байна. Ингэснээр “өндөр татвар” үзүүлэлт 2014-2015 оны түвшинд эргэн ирсэн. Түүнчлэн, 2017 онд “зээл авах боломж” өмнөх оноос илүү дээрдсэн байна. “Зөвшөөрөл, лиценз шинээр авах, сунгуулах” тухайд, 2017 оны хэмжээ дунджаас доогуур байгаа хэдий ч 2016 онтой харьцуулахад 5.4 хувиар өсчээ.

Зураг 3.2: Бизнес тулгарч буй хамгийн гол 3 бэрхшээлийн 2012-2017 оны чиг хандлага



“Өндөр татвар”-ын үзүүлэлт буурахын хэрээр “татварын алба” бэрхшээл учруулах нь багассан гэж судалгаанд оролцогчид үзэж байна. Тодруулбал, татварын алба бэрхшээл учруулдаг гэх үзүүлэлт 2016 оны 35.5 хувиас 2017 онд 22.7 хувь болж огцом буурсан (Зураг 3.3). “Орон нутгийн засаг захиргаа” бизнес эрхлэгчдэд бэрхшээл учруулдаг гэх үзүүлэлт 2017 онд өссөн байна. Энэ үзүүлэлт 2015 оны 6.7 хувиас аажмаар өсч 2017 онд 13.3 хувь болжээ. Мөн “гаалийн байгууллага” 2016 оны 10.9 хувиас 2017 онд 14.2 хувь болж өссөн байна.


Зураг 3.3: Бэрхшээл учруулж буй 4 тэргүүлэх байгууллагын чиг хандлага



Засгийн газар өөрчлөгдөх бүрт агентлаг, байгууллагуудын бүтцийг шинэчилж, нэгтгэх, хуваах, мөн нэрийг нь өөрчлөх практик бий. Энэ нь улс төр, эрх мэдлийн хуваарилалттай холбоотой байдаг. Үүнтэй холбоотойгоор удирдлагын шилжилт, дахин хуваарилалт давхар


явагддаг. Энэ нөхцөл байдал нь судалгааны хэрэгсэлд мөн нөлөөлдөг. Жишээлбэл, 2017 онд “хот төлөвлөлт”-ийг жагсаалтад оруулахад тавдугаар байрт орсон (Зураг 3.4). Мөн өнгөрсөн хугацаанд Мэргэжлийн хяналтын газарт бүтцийн өөрчлөлтүүд хийгдсэн бөгөөд энэ нь тус байгууллагын үнэлгээ, зэрэглэлд нөлөөлсөн.

Зураг 3.4: Бизнес бэрхшээл учруулж буй байгууллагууд (2017)



Бэрхшээл учруулж буй байгууллагуудын үнэлгээ зарим салбарт хүйсийн онцлогтой байна (Зураг 3.5). Эдгээр нь “хот төлөвлөлт”, “гааль” болон “мэргэжлийн хяналтын байгууллага”-д ажиглагдсан.

Зураг 3.5: Бэрхшээл учруулж буй байгууллагууд (хүйсээр)




ҮР АШИГГҮЙ БЭРХШЭЭЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

IV. ҮР АШИГГҮЙ БЭРХШЭЭЛ


Үйлдвэрлэлийн бус саад бэрхшээлд зарцуулдаг цаг хугацааны хэмжээ (“огт зарцуулдаггүй” гэсэн сонголтоос бусад) өмнөх онтой ойролцоо бөгөөд алдааны хязгаар дотор байна (Зураг 4.1). Үйлдвэрлэлийн бус бэрхшээлийг шийдвэрлэхэд удирдах ажилтнуудын 43.9 хувь нь цаг хугацааны 25 хүртэлх хувийг, 13.9 хувь нь 50-иас илүү хувийг зарцуулж байгаа нь өмнөх онтой харьцуулахад 1.8 хувиар өссөн үзүүлэлт юм. “Огт зарцуулдаггүй” буюу цаг хугацаа зарцуулдаггүй гэсэн хариулт 19.7 хувиас 14.8 хувь болж буурчээ.

Зураг 4.1: Танай компани зөвшөөрөл, лиценз авах, сунгах, албан ёсны хариу хүлээх гэх мэт үйлдвэрлэлийн бус асуудлуудыг шийдвэрлэхэд ажлын цагийн хэдэн хувийг үр ашиггүй зарцуулдаг вэ?




Дээрхтэй адилаар хөрөнгө мөнгө зарцуулаагүй компанийн тоо 2017 онд цөөрсөн байна (Зураг 4.2). Цаг хугацаа болон хөрөнгө мөнгө үр ашиггүй зарцуулах нь хоорондоо ихээхэн хамааралтай болохыг шинжилгээ харуулж байна. Цаг хугацааг үр ашиггүй зарцуулах тал дээр (Зураг 4.3) хүйсийн хувьд мэдэгдэхүйц ялгаагүй байхад, хөрөнгө мөнгө үр ашиггүй зарцуулахын хувьд зарим ялгаа ажиглагдаж байна. Тодруулбал, хөрөнгө мөнгөнийхөө 25-аас дээш хувийг үр ашиггүй зарцуулсан гэж мэдээлэх эмэгтэй менежерүүд 9.7 хувь байхад, эрэгтэй менежерүүд 4.1 хувь байна (Зураг 4.4).


Зураг 4.2: Танай компани зөвшөөрөл, лиценз авах, сунгах, албан ёсны хариу хүлээх гэх мэт үйлдвэрлэлийн бус асуудлуудыг шийдвэрлэхэд хөрөнгө мөнгөний хэдэн хувийг үр ашиггүй зарцуулдаг вэ?



Зураг 4.3: Танай компани зөвшөөрөл, лиценз авах, сунгах, албан ёсны хариу хүлээх гэх мэт үйлдвэрлэлийн бус асуудлуудыг шийдвэрлэхэд ажлын цагийн хэдэн хувийг үр ашиггүй зарцуулдаг вэ? (Хүйсээр)



Зураг 4.4: Танай компани зөвшөөрөл, лиценз авах, сунгах, албан ёсны хариу хүлээх гэх мэт үйлдвэрлэлийн бус асуудлуудыг шийдвэрлэхэд хөрөнгө мөнгөнийхөө хэдэн хувийг үр ашиггүй зарцуулдаг вэ? (Хүйсээр)




ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД ДАХЬ АВЛИГА

UIH.MN
СУДАЛГААНЫ САН


V. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД ДАХЬ АВЛИГА

Төрийн байгууллагууд дахь авлигын нөхцөл байдлыг ямар ч ахицгүй гэж тодорхойлж болох юм (Зураг 5.1). 2012 оноос 2014 оны 4 сар хүртэл хугацаанд бага хэмжээний өсөлт, бууралт байсан хэдий ч, судалгаанд оролцогчдын 40 орчим хувь нь төрийн байгууллагуудад авлига “маш их” гэж дүгнэжээ. 2014 оны 9 сард үнэлгээ бага зэрэг сайжирсан боловч 2015 оны 9 сараас хойш судалгаанд оролцогчдын бараг тал хувь нь төрд авлига “маш их” байна гэж хариулсан. Дундаж утгаар харьцуулбал, хандлагын муруй нь төрийн байгууллагуудад авлига нэмэгдэж байгааг харуулж байна. Үнэлгээг 1 оноо буюу авлига “маш их”, 2 буюу “нилээд”, 3 буюу “бага зэрэг”, 4 буюу “огт байхгүй” гэсэн кодоор илэрхийлсэн (Зураг 5.2) Хувийн хэвшлийнхний энэ үнэлгээ нь үнэлгээгээр төрийн байгууллагууд дахь авлига гүнзгийрсэн шинжтэй болсныг харуулж байна.

Зураг 5.1: Таны бодлоор төрийн байгууллагуудад авлига хэр их байна вэ?




Зураг 5.2: Таны бодлоор төрийн байгууллагуудад авлига хэр их байна вэ? (Үнэлгээ 1: “маш их”, 2: “нилээд”, 3: “бага зэрэг”, 4: “огт байхгүй” гэсэн утгуудаар тооцоолсон)



Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад оролцогчдын ажигласан авлигын тохиолдлуудын статистик тоонд онцын ялгаа байхгүй байна (Зураг 5.3). Авлигын талаар мэдээлэх нь эмзэг асуудал тул “байхгүй” утгууд³ ихэвчлэн өндөр байдаг. Тухайлбал, 2017 оны судалгаанд оролцогчдын 37.9 хувь нь энэ талаар ямар нэг хариулт өгөөгүй. “Байхгүй” өгөгдлүүд гол төлөв судлаачдад илүү ач холбогдолтой байдаг тул тайландаа зөвхөн бодит хариултуудыг оруулдаг.

Зураг 5.3: Танай салбар дахь төрийн байгууллага болон компанийн харилцаанд авлигын чанартай зүйл байгааг та хамгийн сүүлд хэзээ ажигласан бэ? (зөвхөн бодит⁴)




Сүүлийн жилүүдэд төрийн байгууллагын гэрээ, тендерийн тал дээр эерэг хандлага ажиглагдаж байна (Зураг 5.4, 5.5). Бизнес эрхлэгчид ингэж үзэхэд нөлөөлсөн хүчин зүйлсийг бодитой

³Хариу байхгүй, “мэдэхгүй”.


⁴“Мэдэхгүй” мөн “хариулаагүй” гэсэн хүчингүй сонголтууд графикаас хасагдсан байгаа.

тодорхойлоход төвөгтэй. Энэ нь эдийн засгийн ерөнхий бууралт болон түүнийг дагасан тендерийн тоо хэмжээ буурсан эсвэл бизнесийн оролцоо хязгаарлагдсантай холбоотой байж болно. Оролцоо буурсанаар ажиглагдах авлигын статистик мөн буурах юм.

Зураг 5.4: Төрийн байгууллагын тендер болон гэрээ байгуулах ажиллагаанд авлига хэр их байна вэ? (зөвхөн бодит хариулт)



Зураг 5.5: Төрийн байгууллага дах авлигын давтамжийн дундаж (Үнэлгээ: 1 оноо "байнга", 2 "нилээд", 3 "хааяа", 4: "огт байгүй")




2016 онтой харьцуулбал авлигад хамгийн их өртсөн салбар, байгууллагуудын 2017 оны үнэлгээнд нилээд өөрчлөлт гарсан (Зураг 5.6). Авлигатай гэх үнэлгээ тодорхой салбаруудад буурсан нь нөхцөл байдал ямар нэгэн байдлаар сайжирч байгааг харуулж байна. Татварын алба хамгийн том амжилтыг гаргасан. 2016 оны 9 сард 29.1 хувь байсан бол 2017 оны 9 сард 18.8 хувь болсон.


2017 оны хувьд Мэргэжлийн хяналтын газар 25.2 хувиар тэргүүлж байгаа хэдий ч 2016 онохоос 2.4 хувиар бага байна. Гаалийн байгууллага 23 хувьтайгаар хоёрдугаар байр руу шилжсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 2 хувиар буурчээ. Харин Ашигт малтмал, газрын тосны газрын үнэлгээ 2016 оны 3.3 хувиас 2017 онд 13.3 хувь болж тааруу үнэлгээ авсан. 2017 оноос эхлэн судалгаанд орсон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 12.1 хувийн үнэлгээ авсан. Засгийн газрын Худалдан авах ажиллагааны агентлаг татан буугдсанаар 2017 оны судалгаанаас хасагдсан болно.

Зураг 5.6: Төрийн байгууллага, агентлагуудаас аль нь хамгийн их авлигад өртсөн бэ? (олон сонголттой хариулт)

а) 2016 оны 9 сар



b) 2017 оны 9 сар




Судалгааны дээрх ажиглалтууд тодорхой зөрчил харагдаж байна. Нэг талаас төрийн байгууллагуудад авлига их байна гэх үзүүлэлт байхад (Зураг 5.5), нөгөө талд төрийн тендер, худалдан авалт дахь авлигын тохиолдол буурч, бизнесийн үйл ажиллагаан дахь нөлөөлөл багассан дүн гарч байна. Тодруулбал, тендерийн нөлөөлөл 2013 оны 10 сард 50 хувь байсан бол аажмаар буурч 2017 онд 36.7 хувь болжээ (Зураг 5.7).


Үүнийг өрхийн түвшинд ажиглагдаж байгаа үйл явцтай холбон тайлбарлаж болох юм. Олон нийтийн төсөөллийн судалгаанд жижиг хэмжээний авлигын тохиолдлууд буурч байгаа статистик үр дүн гардаг. Энэ бууралт 2006 оноос хойш ажиглагдсан. Гэвч эдгээр оролцогчдын үзэж буйгаар нийгэм дэх их авлигын түвшин өндөр байгаа бөгөөд өөрчлөгдөхгүй байна. Өөрөөр хэлбэл, жижиг авлигын асуудлыг судалгаанд оролцогчид өөрсдөө биечлэн харж, мэдэрч байдаг бол их авлигын талаарх үнэлгээ нь хэвлэл мэдээлэл болон цуу ярианаас үүдэлтэй бодит бус төсөөлөл юм.

Бизнесийн орчинд дээрхтэй адил нөхцөл байдал ажиглагдаж байна. Авлигын тохиолдлууд нь доод түвшинд буюу бизнесийн үйл ажиллагаа харагдах хэсэгт цөөрч, улмаар тодорхой хэсэг нь нууц далд буюу дээд түвшинд шилжиж байна гэж таамаглаж болохоор байна. Ихэнх бизнесийн оролцогчдоод их авлига ажиглагдаагүй бөгөөд ойлголт мэдлэг нь төсөөлөл, таамаглалын хэмжээнд байна. Тиймээс их авлига бизнест "маш ихээр" нөлөөлж байна гэсэн үзүүлэлт 2016 оны 11.5 хувиас 2017 онд 9.4 хувь болж буурсан нь бодит ажиглалтаас бус, эдийн засгийн өсөлттэй холбоотой гэж ойлгож болно. Судалгаанд оролцогчдын 24.8 хувь нь төрийн байгууллагын тендерт оролцсон гэдгээ мэдээлсэн тул тендертэй холбоотой судалгааны үзүүлэлт нь тодорхой үндэслэлтэй юм (Зураг 5.8).


Зураг 5.7: Төрийн байгууллага дахь авлига танай бизнест шууд нөлөөлж байна уу? (зөвхөн бодит)



Зураг 5.8: Танай компани засгийн газрын тендерт оролцдог уу?




Зураг 5.9: Их авлига буюу дээд түвшний авлига танай бизнест хэр их нөлөөлж байна вэ?




Авлига төрийн байгууллагуудад ямар байдлаар тархаж байгаа 2017 оны үнэлгээ 2016 оныхтой бараг төстэй байна. Үүнээс харахад бизнес эрхлэгчдийн ойролцоогоор 70 хувь нь авлигын үйл ажиллагаа “зохион байгуулалттай бүлгийн” хэлбэрээр явж байна гэж үзэж байна (Зураг 5.10).

2017 оны судалгааны үеэр Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн Засгийн газар бүрдэж байсан тул энэ Засгийн газрын үйл ажиллагааг үнэлэх боломжгүй байлаа. Гэсэн хэдий ч шинээр байгуулагдсан засагт итгэх итгэлийн түвшинд эерэг байв (Зураг 5.11). Оролцогчдын 35.5 хувь тендерийн үйл ажиллагаа сайжирна гэсэн хүлээлттэй байсан бол ердөө 4.8 хувь нь дордоно гэж үзэж байв. Мөн 40.6 хувь нь юу болох талаар ямар нэг санал бодолгүй байсан (Зураг 5.12). Үүний зэрэгцээ Монгол дахь өнөөдрийн авлигын түвшин гурван жилийн өмнөхөөс илүү дордсон гэдэг төсөөлөл байна (Зураг 5.13).


Зураг 5.10: Төрийн байгууллага дахь авлига хувь хүмүүс хоорондын харилцааны хүрээнд байна уу, эсвэл зохион байгуулалттай бүлэглэлийн хэмжээнд очсон байна уу?




Зураг 5.11: Хэрэв У.Хүрэлсүх Ерөнхий сайд болвол төрийн тендер болон худалдан авах ажиллагаа өмнөх Засгийн газартай харьцуулахад хэр их өөрчлөгдөх вэ?



Зураг 5.12: Таны бодлоор улс төр, гэр бүл, ах дүү, танилын харилцаа тендерийн үр дүнд нөлөөлдөг үү?



Зураг 5.13: Өнгөрсөн гурван жилд Монголын бизнесийн орчинд авлигын түвшин хэр зэрэг өөрчлөгдсөн бэ?



ХУВИЙН ХЭВШИЛ ДЭХ АВЛИГА


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

VI. ХУВИЙН ХЭВШИЛ ДЭХ АВЛИГА


Хувийн хэвшил дэх авлигын үнэлгээнд буурах хандлага ажиглагдаж байна (Зураг 6.1.а-б). 2014 оноос энэ үзүүлэлт 3 оноо буюу “бага зэрэг” түвшинд байна (Зураг 6.1.б). Харин 2017 оныг 2016 онтой харьцуулбал үнэлгээ дордсон байна. Авлигын дундаж түвшин бага зэрэг буюу 0.09 хувь буурсан хэдий ч авлига “бага зэрэг” болон “нилээд” хэмжээнд байна гэж үзэх хүмүүсийн тоо 6.6 хувиар өссөн. Хувийн хэвшил дэх авлигын үнэлгээг хүйсээр ялгаж харвал хариу өгөөгүй оролцогчдын эмэгтэйчүүдийн тоо илүү өндөр байна (Зураг 6.2). Хариултыг мэдэхгүй эсвэл хариу өгөхөөс татгалзсан эмэгтэй менежерүүдийн тоо 13.1 хувь байхад эрэгтэйчүүд 4.7 хувь байна. Эмэгтэйчүүдийн авлигын түвшингийн зөрөг үнэлгээ эрэгтэй удирдах ажилтнуудаас доогуур байна.

Зураг 6.1: Хувийн хэвшилд авлига хэр их байна вэ? (зөвхөн хүчинтэй хариулт)


а)



- б) Хувийн хэвшил дэх авлигын үнэлгээний дундаж (Үнэлгээ: 1 оноо “маш их”, 2 оноо “нилээд”, 3 оноо “бага зэрэг” 4 оноо “байхгүй”).



Зураг 6.2: Хувийн хэвшилд авлига хэр их байна вэ? (Хүйсээр)




Өмнөх онтой харьцуулахад хувийн хэвшил дэх тендер болон гэрээ байгуулахад тохиолддог авлигын талаарх үнэлгээ 2017 онд бага зэрэг өссөн (Зураг 6.3). Гэвч судалгаа эхэлсэн 2012 оны 12 сартай харьцуулахад 2016, 2017 оны үзүүлэлт хамгийн бага хэмжээнд байна. Бизнесийн үйл ажиллагаан дахь авлигын үзүүлэлт нь тендер болон гэрээ байгуулах явцад авлига тохиолддог гэх үзүүлэлтээс бага байна (Зураг 6.4). Тендер болон гэрээ байгуулах үеийн авлигын дундаж 2.41 байхад үйл ажиллагаа явуулах үе дэх авлигын дундаж 2.89 байна.


Өнгөрсөн жилтэй харьцуулахад үйл ажиллагааны явцад авлига тохиолддог гэх тааруу үзүүлэлт “үйлчилгээ”-ний салбарт илүү ажиглагдсан (Зураг 6.5).

Зураг 6.3: Хувийн хэвшил дэх тендер болон гэрээ байгуулах ажиллагаанд авлига хэр их тохиолддог вэ? (зөвхөн хүчинтэй хариулт)

а)




б) Авлигын тохиолдлын дундаж (Үнэлгээ: 1 оноо "байнга", 2 оноо "нилээд", 3 оноо "Хааяа", 4 оноо "хэзээ ч тохиолддоггүй")




Зураг 6.4: Танай бизнесийн салбарт үйл ажиллагаа явуулахад авлига хэр их тохиолддог вэ? (зөвхөн хүчинтэй хариулт)

а)




б) Авлигын тохиолдлын дундаж (Үнэлгээ: 1 оноо "байнга", 2 оноо "нилээд", 3 оноо "Хааяа", 4 оноо "хэзээ ч тохиолддоггүй")




Зураг 6.5: Танай салбарт бизнесийн үйл ажиллагаа явуулахад авлига хэр их тохиолддог вэ?


а) Үйлчилгээ




б) Худалдаа



в) Үйлдвэрлэл




г) Барилга




Уул уурхай болон төрийн үйлчилгээ нь авлигад хамгийн өртөмтгий салбарын тоонд орсон хэвээр байна (Зураг 6.6). Харин 2015 оноос эхлэн барилга, худалдаа болон үйлдвэрлэлийн салбарт авлигын чиг хандлага буурч байна. “Татвараа зохих ёсоор төлдөг компани байхгүй” гэх хариултыг 2017 оны судалгаанд оролцогчдын 4.5 хувь нь өгчээ (Зураг 6.7). Энэ нь бүх хугацааны хамгийн бага үзүүлэлт юм.

Зураг 6.6: Авлигад хамгийн өртөмтгий салбар (олон хариулт)


а) Төрийн үйлчилгээ




б) Уул уурхай




в) Барилга




г) Санхүү




д) Худалдаа




е) Цахилгаан, дулаан, ус



ё) Үйлдвэрлэл



Зураг 6.7: Танай салбарт хэр олон компаниуд татвараа номоор нь /хууль ёсны дагуу/ төлдөг вэ? (зөвхөн бодит)



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

VII. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА


2012-2017 оны хооронд Монгол Улсад дөрвөн Засгийн газар солигдож гурван сонгууль явагджээ. Сүүлийн судалгаа хийгдэх үед дөрөв дэх Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн Засгийн газар байгуулагдсан. Энэ хугацаан дахь Засгийн газрын авлигатай тэмцэх хүчин чармайлтын үнэлгээ буурах хандлагатай байна (Зураг 7.1). Гол шалтгаан нь олон нийтэд хүрсэн дорвитой бодлого, үйл ажиллагааг богино хугацаатай Засгийн газрууд гаргаж чадахгүй байгаа явдал юм. Гэвч 2017 оныг 2016 онтой харьцуулахад үнэлгээ бага зэрэг сайжирчээ. Мөн авлигын эсрэг хууль тогтоомжийн үр нөлөөний хувьд хамгийн муу үзүүлэлт 2016 онд гарсан боловч 2017 онд бага зэрэг сайжирсан (Зураг 7.2).

Зураг 7.1: Та Засгийн газраас явуулж байгаа авлигын эсрэг үйл ажиллагааны талаар хэр сайн мэдэх вэ?

а)




б) Засгийн газрын авлигын эсрэг үйл ажиллагааны мэдлэгийн дундаж утга (Үнэлгээ: 1 оноо "маш их мэднэ", 2 оноо "тодорхой хэмжээнд мэднэ, 3 оноо "бараг мэдэхгүй, 4 оноо "огт мэдэхгүй")




Зураг 7.2: Одоогийн үйлчилж байгаа авлигын эсрэг хууль тогтоомж бизнесийн орчныг ил тод, авлигагүй болгоход хэр үр дүнтэй байна вэ?

а)




б) Авлигын эсрэг хууль тогтоомжийн үнэлгээний дундаж утга (Үнэлгээ: 1 оноо "маш үр дүнтэй", 2 оноо "нилээд үр дүнтэй", 3 оноо "бага зэрэг үр дүнтэй", 4 оноо "огт үр дүнгүй").



Авлигын нөхцөл байдлыг 6 сарын өмнөх буюу Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын үетэй харьцуулбал үнэлээ муудах байдал харагдаж байна (Зураг 7.3). Тодруулбал, авлига нэмэгдсэн гэх үзүүлэлт 2016 оны 9 сард 7.6 хувь байсан бол 2017 оны 9 сард 9.7 хувь болж нэмэгджээ.


Зураг 7.3: 6 сарын өмнөхтэй харьцуулбал Засгийн газраас хэрэгжүүлж буй авлигын эсрэг арга хэмжээний үр дүнд нөхцөл байдал өөрчлөгдсөн үү?




2016 оны 9 сард Засгийн газрын авлигын эсрэг хэрэгжүүлж буй ажлын үнэлгээнд өсөлт ажиглагдсан. Энэ 2.98 үнэлгээ нь Ерөнхий сайд Н.Алтанхуягийн Засгийн газрын эхэн үеийн буюу 2012 оны 9 сарын дундаж утгатай ойролцоо байна (Зураг 7.4.б). Томилогдсоноос хойш ийм богино хугацаанд бодит ажил хийгдэх боломж бага учраас энэ нь нь шинээр Засгийн газар байгуулагдах бүрт бий болдог хандлага болох нь харагдаж байна. Түүнчлэн авлигатай тэмцэх ажлын үнэлгээнд өгөх хандлага ерөнхийдөө муудаж байна.

Зураг 7.4. Ерөнхийд нь авч үзвэл Засгийн газраас хэрэгжүүлж буй авлигын эсрэг арга хэмжээнүүд Монголыг авлигагүй болгоход хэр үр дүнтэй байна вэ?

а)




б) Засгийн газраас хэрэгжүүлж буй авлигын эсрэг арга хэмжээний үнэлгээний дундаж (Үнэлгээ: 1 оноо "маш үр дүнтэй", 2 оноо "нилээд үр дүнтэй", 3 оноо "бага зэрэг үр дүнтэй", 4 оноо "огт үр дүнгүй")




Авлигач албан тушаалтнуудад хариуцлага тооцох асуудал дээр бизнес эрхлэгчид сэтгэл дундуур байна. 2012 онд оролцогчдын 43.6 хувь Засгийн газар авлигач албан тушаалтанд хариуцлага тооцож чадахгүй байна гэж үзэж байсан бол 2017 оны 9 сард 73 хувь болж

нэмэгджээ (Зураг 7.5). Хээл хахууль өгсөн болон авсан хоёуланг шийтгэхийг илүү дэмжих болсон нь нэгэнт авсан талд хариуцлага тооцохгүй байгаатай холбоотой байж болно (Зураг 7.6).

Зураг 7.5: Засгийн газар авлигач албан тушаалтнуудад хариуцлага тооцож чадаж байна уу?




Зураг 7.6: Зөвхөн хээл хахууль авсан талд хариуцлага тооцохоор хуульд өөрчлөлт оруулбал үр дүнтэй гэж зарим хүмүүс үздэг. Зарим нь өгсөн, авсан аль алинд хариуцлага тооцох ёстой гэж үздэг. Таны бодол?




Өмнөх үзүүлэлтүүдтэй харьцуулахад илүү олон оролцогчид авлига буурах нь тэдний бизнест ямар нөлөө үзүүлэхийг хэлж чадахгүй байна. 2016 онд тэдгээрийн тоо 14.8 хувь байсан бол 2017 онд 21.8 хувь болжээ (Зураг 7.7). Оролцогчдын дунджаар тал хувь нь төрийн байгууллагуудад авлига буурвал тэдний цэвэр орлого нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байна. 2016, 2017 онд энэхүү хүлээлт 2012-2015 оныхоос доогуур байна.


Зураг 7.7: Хэрэв төрийн байгууллагуудад авлига багасвал танай компанийн нийт орлого нэмэгдэх үү, буурах уу, эсвэл хэвээр үлдэх үү?




Авлигатай тэмцэх арга хэмжээ авч байгаа оролцогчийн тоо 2017 онд хамгийн өндөр буюу 15.2 хувьтай байна (Зураг 7.8). Энэ нь авлигыг мэдээлэхээс өөр алхам байх талтай юм. Учир нь авлигыг мэдээлсэн гэх хүмүүсийн тоо 2016 онд 9.1 хувь байснаас 2017 онд 6.1 хувь болж буурсан юм (Зураг 7.9). 2014 онд судалгаанд оролцогчдын 13.8 хувь нь мэдээлэл өгснөөр зарим үр дүн гарсан гэж мэдээлсэн бол 2017 оны 9 сард энэ хариу 25 хувьд хүрчээ (Зураг 7.10). Авлигын талаар мэдээлэхэд хүйсийн онцын ялгаа ажиглагдсангүй (Зураг 7.9.6). Байгууллага авлигын эсрэг дүрэм, журамтай эсэх мэдээлэлд бууралт хэвээр байна. 2017 онд оролцогчдын ердөө 13.9 хувь ийм бодлого, баримт бичигтэй гэж хариулжээ (Зураг 7.11).

Зураг 7.8: Танай компани авлигатай тэмцэх ямар нэгэн алхам хийсэн үү?**Зураг 7.9:** Та авлигын талаар мэдээлэл өгч байсан уу?


а)




б) Та авлигын талаар мэдээлэл өгч байсан уу? (Хүйсээр)




Зураг 7.10. Хэрвээ өгсөн бол ямар нэг үр дүнд хүрч байсан уу?



Зураг 7.11: Танай байгууллагад авлигын эсрэг дотоод дүрэм журам бий юу?

2017 онд авлигын эсрэг арга замын тухай асуултыг ерөнхийгөөс идэвхтэй болгон өөрчилсөн. Энэ нь авлигыг бууруулахад бизнесийн байгууллага ямар үйл ажиллагааг сонгохыг асуудаг (Зураг 7.12). Бизнес эрхлэгчид шударга зарчмаар ажиллах, хахууль өгөхгүй байх, хууль дүрмийн мэдлэгтэй байх гэх мэт алхмыг илүүд үзэж байна. 6.1 хувь нь “авлигач улс төрчдийн эсрэг компанит ажил явуулах”-ыг, 3.6 хувь нь “авлигын эсрэг иргэний нийгмийн санаачлагад нэгдэх” хариултыг сонгосон нь бизнесүүд авлигын эсрэг үйл ажиллагаанд илүү идэвх, санаачлагатай оролцох сонирхол багатайг харуулж байна. Энэ хандлага нь нөхцөл байдлыг ойрын хугацаанд сайжруулахад хувь нэмэр оруулахгүй нь тодорхой байна. Энэхүү идэвхгүй байр суурь нь авлигатай тэмцэх байгууллагын ажлын үнэлгээний бууралттай ижил байна. Авлигатай тэмцэх газрын ажлыг “муу” гэсэн үнэлгээ 2016 оны 17.6 хувиас 2017 онд 27.9 хувь болж өссөн.

Зураг 7.12: Бизнесийн орчин дахь авлигаыг арилгахын тулд танай байгууллага ямар аргыг сонгох вэ?

Зураг 7.13. Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг Та хэрхэн үнэлж байна вэ?